



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 60

Мандалговь

Аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ыг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийг 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Энхсүх)-д даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12дугаар сарын 05-ны өдрийн
60 дугаар тогтоолын хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ-2030
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аймгийн нийт нутаг дэвсгэр 7469,0 га, 15 сум, 68 багтай нийт 47,5 мянган хүн амьдарч байна. Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сүмтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг “Ембүү дэrsэнэ ус” гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагджээ. 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт суурьшсан байна. Дундговь аймаг нь Монгол Улсын нийт газар нутгийн 4,5%-ийг эзэлдэг. Дундговь аймгийн Өлзийт суманд Заган ойн Улсын тусгай хамгаалалттай бус нутагтай. Заган ойн сангийн нийт талбай 32759 га талбай байгаагаас 16852 га буюу 51,4 хувь нь ойгоор бүрхэгдсэн талбай, 15907 га буюу 48,6 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 16793 га буюу 99.64 хувийг байгалийн заган ой 16 га буюу 0,09 хувийг сөөг, 43 га буюу 0,25 хувийг тармаг заг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 14953 га буюу 94,0 хувийг тармаг заг, 954 га буюу 6,0 хувийг ойжих талбай тус тус эзэлж байна. Шороон шуурганы давтагдал жилээс жилд нэмэгдэж 2016 оноос 2020 он гэхэд даруй 182 -оор, 15 м/с-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо 3 дахин, нөөлөг салхитай өдрийн тоо 4 дахин өссөн байна. Аймгийн нийт нутгийн 90 гаруй хувьд цөлжилт эрчимтэй явагдаж байгаа нь аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх үндэслэл болно.

ХОЁР. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ойн менежментийн төлөвлөгөөний зорилго нь Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймаг 30 сая мод, сөөг тарьж ургуулах хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангахад оршино.

Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, ойг хамгаалах нөхөн сэргээх, хомсдол доройтлыг бууруулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгож, иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой ойжуулалт хийх, ойн зурvas байгуулж агро ойн аж ахуйг хөгжүүлэх, байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжиж ойгоор бүрхэгдсэн талбай, төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг зөв менежментийн тогтолцоог бий болгох зорилготой.

Ойн менежментийн мастер төлөвлөгөөний зорилгыг 6 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

2.1. Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 2.1.1. Төрөөс баримтлах ойн бодлогыг орон нутгийн онцлогт уялдуулан боловсруулах
- 2.1.2. “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэх
- 2.1.3. Уст цэгийн тооллого, судалгааг үндэслэн хөв цөөрөм байгуулах газрыг сонгох, булаг шанд хашиж хамгаалах ажлыг төлөвлөх
- 2.1.4. Булаг шанд хашсан газрыг түшиглэн ойн зурvas байгуулах
- 2.1.5. Цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг ногоон байгууламж, ойн зурvas, мод сөөгийн усалгаанд ашиглах
- 2.1.6. Мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, хамтран ажиллах
- 2.1.7. 2023-2030 он хүртэл мод тарих, ойн зурvas байгуулах талбайг үе шаттай төлөвлөх, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах
- 2.1.8. Айл өрхийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор “Хашаандаа сайхан амьдаръя” аяныг өрнүүлэх
- 2.1.9. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг политехникийн коллеж, их дээд, сургуулиудтай хамтран ажиллах
- 2.1.10. Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэх
- 2.1.11. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 50 га талбайд ойн зурvas, мод үржүүлгийн газар, агро парк байгуулах

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.2. Үр болон тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

- 2.2.1. Байгалийн болон таримал ойн сангийн талбайгаас мод сөөгийн үр, мөчир бэлтгэх, нөөц бий болгох
- 2.2.2. Орон нутгийн мод үржүүлгийн газруудыг дэмжих, шинээр байгуулах
- 2.2.3. Мод үржүүлгийн газрын үр, тарьц суулгацын мэдээг нэгтгэн мэдээллийн сан бий болгох, олон нийтэд мэдээлэх

Гуравдугаар зорилтын хүрээнд:

2.3. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурvas байгуулах ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

- 2.3.1. Төв суурин газарт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх
- 2.3.2. Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах
- 2.3.3. Хамгаалалтын ойн зурvasыг байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх

- 2.3.4. Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах
- 2.3.5. Байгалийн болон таримал ойн зурвасууд, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид хортон шавжийн судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулах
- 2.3.6. Ойжуулалт, ойн зурvas талбайн цаашдын арчилгаа хамгаалалт, хөгжүүлэлтэд иргэд, олон нийтийн бүлэг, хоршооллыг бэлтгэх

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

- 2.4. Дэвшилтэд технологи, техник багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийг бий болгох зорилтыг хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.
 - 2.4.1. Бордооны үйлдвэр байгуулах, үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах
 - 2.4.2. Ногоон байгууламжийн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж усалгааны систем, холбогдох тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, нэмэгдүүлэх
 - 2.4.3. Олон наст модлог ургамлын хэрэглээг зогсоож, орлох түлшний хэрэглээг нэвтрүүлнэ
 - 2.4.4. Усыг хэмнэлттэй ашиглах төлөвшлийг бий болгож, дэвшилтэд технологийн усалгааны системийг нэвтрүүлэх

Тав дугаар зорилтын хүрээнд:

- 2.5. Сургалт, сурталчилгаа зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

- 2.5.1. Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад хамрагдах
- 2.5.2. Аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, аргазүйгээр хангаж ажиллах
- 2.5.3. Туршлага судлах

Зургаадугаар зорилтын хүрээнд:

- 2.6. Санхүүгийн тогтвортой механизм бий болгох
 - 2.6.1. Улсын болон орон нутгийн төсөв
 - 2.6.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусалж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
 - 2.6.3. Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө
 - 2.6.4. Бусад санхүүгийн эх үүсвэр

ГУРАВ. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

3.1 Ойн менежментийн мастер төлөвлөгөөг 2023-2030 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Бэлтгэл ажил хангаж ажлыг эхлүүлэх 2022-2024
- Мод тарьж ургуулах, ойжуулах ажлыг зохион байгуулах 2025-2028
- Амьдралт, ургалт, өсөлтийг дэмжих, арчлах 2029-2030

ДӨРӨВ. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР НӨЛӨӨ,

БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.
- 4.1.1. Байгалийн заган ойн сангийн талбайн хэмжээ нэмэгдэж, ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь өснө.
- 4.1.2. Мэргэжлийн аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой сайжирна.
- 4.1.3. Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ нэмэгдэнэ
- 4.1.4. Хамгаалалтын зориулалттай ойн зурvasууд бий болж агро ойн аж ахуй хөгжинө.
- 4.1.5. Байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавх нэмэгдэнэ.
- 4.1.6. Мод үржүүлгийн газар, ойжуулалт, ойн зурvas байгуулах, агро ойн аж ахуйд суурилсан ажлын байрны тоо нэмэгдэж, амьжирагааны эдийн засгийн боломжууд бий болж, ажилгүйдлийн хувь буурна.
- 4.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг дүгнэхдээ 2023-2030 оныг хүртэл хийгдсэн ажлын үр дүнгээр дүгнэнэ.

2022 оны жилийн эцсийн үзүүлэлт, ойн зохион байгуулалтын мэдээг суурь үзүүлэлт болгон ашиглана.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин /2030 он/
1	Мод үржүүлгийн газруудыг нэмэгдүүлж, говь цөлийн бүсийн мод, сөөгийг үр болон мөчрөөр үржүүлэх	Тоо хэмжээ	3	15
2	Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулалт хийх	га	-	1800
3	Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	га	74	225
4	Ойн зурvas талбай байгуулах	га	417.4	45276

ТАВ. ОЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

- 5.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах эх үүсгэврээс санхүүжүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв

- Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусалж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө
- Бусад санхүүгийн эх үүсвэр

ЗУРГАА. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, Дундговь аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030 ”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах улсын хэмжээний болон орон нутгийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсөв, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн санхүүжилтийг судалж, нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг БОАЖЯ, АЗДТГ хариуцна.

6.3. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах, иргэд аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжих, мод тарьж ургуулах ажилд бүх нийтийг хамруулах, уриалах, өрхийн болон жижиг, дунд мод үржүүлэг болон хөрс бордооны жижиг дунд үйлдвэрлэлийг нэвтрүүлж, ажлын байрыг бий болгох чиг үүргийг бүх шатны Засаг дарга нар хариуцна.

6.4. Мод үржүүлгийн газар, ойн зурvas байгуулах, ойжуулалт хийх талбайг тухайн аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, талбай олгох асуудлыг харьяа сумын Засаг дарга нар хариуцна.

6.5. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа, үр, тарьц суулгацын стандарт, чанарын асуудал болон бэлтгэх, нийлүүлэх ажлыг тухайн аж ахуйн нэгж аймгийн БОАЖГазар, СДОАнги хамтран хариуцна.

6.6. Иргэдийн бүлэг, сайн дурын зөвлөлүүд, хоршоо, төрийн болон хувийн хэвшилийн байгууллагуудыг мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг аймгийн БОАЖГ, СДОА, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулна.

ДОЛОО. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭ

7.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг АЗДТГ, БОАЖГ, СДОА, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр хийнэ.

- 7.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт бүрийн хэрэгжилтийн хянал-шинжилгээг АЗДТГ,БОАЖГ, СДОА хариуцан гүйцэтгэж, тайлангаа жил бүр аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-аар хэлэлцүүлж БОАЖЯаманд хүргүүлнэ.
- 7.3. Орон нутгийн хэмжээд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг сумын Засаг дарга, ЗДТГ, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар хариуцан гүйцэтгэж, тайлангаа аймгийн БОАЖГ-т ирүүлнэ.
- 7.4. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт өөрчлөлт, эрхзүйн зохицуулалт оруулж болно.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ -2030

Д/Д	Хөтөлбөр (Хөтөлбөрийн нэр) хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хэрэгжилтийн хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2023-2024	2025-2027	2028-2030		
Зорилт 1: Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг								
1.1	Төрөөс баримтлах ойн бодлогыг орон нутгийн онцлогт уялдуулан боловсруулах	Бодлогын баримт бичиг, төлөвлөгөө	-	“Ойн менежментийн мастер төлөвлөгөө- 2030” –г боловсруулж, батлуулсан байна.			БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	-
1.2	“Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Модны тоо	221640	500.000	700.000	1.000.000	АЗДТГ, БОАЖГ СДОА	Албан байгууллага, аж ахуйн нэгж
1.3	Үст цэгийн тооллого, судалгааг үндэслэн хөв цөөрөм байгуулах газрыг сонгох, булаг шанд хашиж хамгаалах ажлыг төлөвлөх	Байгуулах хөв, цөөрөм болон хаших булаг шандын тоо	59	62	65	68	АЗДТГ, БОАЖГ	Аж ахуйн нэгж байгууллагууд, сумд
1.4	Хашиж хамгаалсан булаг шандыг түшиглэн ойн зурvas байгуулах	ойн зурvasын талбайн хэмжээ	-	1	2	3	АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж байгууллагууд
1.5	Цэвэрлэх байгууламжийн саарал усыг ногоон байгууламж, ойн зурvas, мод сөөгийн усалгаанд ашиглах	Ашиглах усны хэмжээ /хувиар/	-	85-90%			АЗДТГазар	БОАЖГ, СДОА, ХТГазар, Дундговь-Ус ОНӨААТҮГ
1.6	Мэргэжлийн аж ахуйн нэгж байгуулах, хамтран ажиллах	Ойн мэргэжлийн байгууллагын тоо	2	-	3	4	АЗДТГазар	БОАЖГ; СДОА
	2023-2030 он хүртэл мод тарих, ойн зурvas байгуулах талбайг үе		750.91	45276			АЗДТГазар, ГХБХБГазар,	БОАЖГ, СДОА

1.7	шаттай төлөвлөх, Газар зохион байгууллалтын төлөвлөгөөнд тусган батлуулах	га					Сумдын ЗДТГ	
1.8	Айл өрхийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор “Хашаандаа сайхан амьдаръя” аяныг өрнүүлэх	Өрхийн тоо	-		100		АЗДТГ	БОАЖГ, СДОА ААН, байгууллагууд
1.9	Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их дээд, сургууль, политехникийн коллеж той хамтран ажиллах	Суралцагчийн тоо	4	6	8	10	АЗДТГ	Их дээд сургуулиуд, коллеж
1.10	Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэх						АЗДТГ	
1.11	Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар ойн зурсас, мод үржүүлгийн газар, агро парк байгуулах	Талбайн хэмжээ /га/	-		50		АЗДТГ, БОАЖГ	Эрдэнэт үйлдвэр

Зорилт 2: Үр болон тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх

2.1	Байгалийн болон таримал ойн сангийн талбайгаас мод сөөгийн үр, мөчир бэлтгэх, нөөц бий болгох	Үр /кг/ Мөчир /ш/	50 8000	70 12000	100 15000	120 20000	СДОА	Иргэд, ААН, байгууллагууд
2.2	Орон нутгийн мод үржүүлгийн газруудыг дэмжих, шинээр байгуулах	Мод үржүүлгийн газрын тоо	3		18		АЗДТГ, БОАЖГ, СДОА	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд

2.3	Мод үржүүлгийн газрын үр, тарьц суулгацын мэдээг нэгтгэн мэдээллийн сан бий болгох, олон нийтэд мэдээлэх	Мэдээний тоо	1	9	БОАЖГ	СДОА, Сумд
-----	--	--------------	---	---	-------	------------

Зорилт 3: Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурvas байгуулах, арчлан ургуулах ажлыг зохион байгуулах

3.1	Төв суурин газарт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх	га	417.4	225	АЗДТГ БОАЖГ	Сумд
3.2	Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах	га	-	1800	БОАЖГ, СДОА	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд
3.3	Хамгаалалтын ойн зурvasыг байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх	га	417.4	45276	БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт
3.4	Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	2	16	БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт
3.5	Байгалийн болон таримал ойн зурvasууд, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид хортон шавжийн судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	-	8	БОАЖЯ, ОСХТ, БОАЖГ, СДОА	Мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд болон бусад аж ахуйн нэгж байгууллага

3.6	Ойжуулалт, ойн зурvas талбайн цаашдын арчилгаа хамгаалалт, хөгжүүлэлтийг иргэдийн бүлэг, хоршоололд хариуцуулах, дэмжих	Талбайн хэмжээ /га/	417.4	45276			БОАЖЯ, ОСХТ УТҮГ, БОАЖГ, СДОА	Иргэд, олон нийтийн сайн дурын бүлэг, хоршоолол, нөхөрлөл, мэргэжлийн байгууллага
3.7	Гүний худаг гаргуулахаар зөвшөөрөл авч байгаа айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагаар мод тариулах (нэг худаг – 20 ширхэг мод)	Тарьсан модны тоо	-	200	400	600	БОАЖГ, СДОА	Айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллага

Зорилт 4: Дэвшилтэд технологи, техник багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийг бий болгох

4.1	Бордоо үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах						АЗДТГ	ААН, байгууллага
4.2	Ногоон байгууламжийн худаг, уст цэгийн тоо, усалгааны систем, холбогдох тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Уст цэгийн тоогоор	12	27			АЗДТГ, БОАЖГ	СДОА, Сумд, аж ахуйн нэгж байгууллагууд
4.3	Олон наст модлог ургамлын хэрэглээг зогсоож, орлох түлшний хэрэглээг нэвтрүүлнэ.	Нэвтрүүлсэн түлшний тоо	0	1			АЗДТГ, БОАЖГ	ААН, байгууллага
4.4	Усыг хэмнэлттэй ашиглах төлөвшлийг бий болгож, дэвшилтэд технологийн усалгааны системийг нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	0	3			АЗДТГ, БОАЖГ	ААН, байгууллага

Зорилт 5: Сургалт, сурталчилгаа зохион байгуулах

5.1	Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад хамруулах	Сургалтын тоо	4	8			АЗДТГ, Их дээд сургуулиуд	БОАЖГ, СДОА
5.2	Аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, аргазүйгээр хангах сургалт зохион байгуулах	Хамрагдсан хүний тоо	75	600			БОАЖГ, СДОА	Мэргэжлийн байгууллага
5.3	“Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд бүлэг байгуулж, сурган дадлагажуулах	Хамрагдсан хүний тоо	229	429	629	700	АЗДТГ	БОАЖГ, СДОА
5.4	Туршлага судлах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-			АЗДТГ	БОАЖГ, СДОА

Зорилт 6: Санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох

6.1	Улсын болон орон нутгийн төсөв
6.2	Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусlamж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
6.3	Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө
6.4	Бусад эх үүсвэр